



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

# ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2025 он

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГАТАЙ ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛҮҮЛЭН  
ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ  
ТАЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

**1. Гэрээ байгуулагч Талууд:**

**1.1 Нэг талаас:**

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА**

**Есентай ЗАНГАР**

**1.2.Нөгөө талаас:**

**АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**

**Хумар АНЖЕЛИКА**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2 дахь хэсэгт заасныг үндэслэн бид дор дурдсан асуудлаар харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

**НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА, ЗОРИЛГО**

1. "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө" нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд байгууллагын удирдлагаас хэрэгжүүлэх гүйцэтгэлийн зорилт, хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, эх үүсвэрийг тодорхойлж тусгав.

2. Энэхүү гэрээний зорилго нь Монгол улсын сайд, Засгийн газрын гишүүнтэй аймгийн Засаг дарга 2025 онд хамтран ажиллах гэрээний холбогдох заалтын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сонирхлын зөрчилгүй ажиллах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсвийн болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах зэрэг манлайллын зорилтуудыг хангах талаар байгууллагын удирдлагын 2025 онд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино.

**ХОЁР. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

**2.1. Аймгийн Засаг даргын хүлээх үүрэг:**

2.1.1. Байгууллагын удирдлагатай байгуулах гүйцэтгэлийн гэрээнд тусгаж хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ тус бүрээр гүйцэтгэлийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

2.1.2. Тухайн жилийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

2.1.3. Гэрээнд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд нь байгууллагын удирдлагад байнгын дэмжлэг туслалцаа үзүүлж, гэрээний биелэлтийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

2.1.4. Төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийг "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

нийтлэг журам” болон аймгийн Засаг даргын 2024 оны А/519 дүгээр захирамжийн хавсралтын дагуу үнэлнэ.

2.1.5. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

## **2.2. Байгууллагын удирдлагын хүлээх үүрэг**

2.2.1. Энэхүү гэрээний хавсралт болох “Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээнээс гадна дараах арга хэмжээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлнэ;

2.2.2. Байгууллагын удирдлага нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Монгол улсын Иргэний хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, тухайн салбарын үйл ажиллагааг зохицуулах хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээж, үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцна;

2.2.3. Бодлогын баримт бичгүүд болох Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох зорилт, арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг хангуулж, аймгийн Засаг даргын Тамгын газарт журамд заасан хугацаанд тайлагнах;

2.2.4. Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийн ИТХ-ын болон аймгийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах явцад бодитой ажил зохион байгуулж, үр дүнг нэмэгдүүлэх тал дээр санаа, санаачлага гарган, хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудтай уялдаатай ажиллах, гүйцэтгэлийг чанаржуулж, биелэлтийг журамд заасан хугацаанд тайлагнаж ажиллана;

2.2.5. Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж төрийн ажил, үйлчилгээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг тогтмолжуулж хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлнэ;

2.2.6. Байгууллагын өмч, эд хөрөнгийн бүртгэл, ашиглалт хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг хангана;

2.2.7. Батлагдсан төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг сар бүр жигд ханган биелүүлнэ;

2.2.8. Албаны болон хувийн ажлаар гадаад улс руу болон дотоодод явахдаа аймгийн Засаг даргын Тамгын газарт мэдэгдэж, томилолт, удирдамж, хөтөлбөрөө батлуулж, зөвшөөрөл авна. Дипломат болон албаны гадаад паспортыг зөвхөн албаны хэргээр ашиглах ба хувийн хэргээр гадаадад зорчихдоо албан ёсны уулзалт, яриа хэлэлцээ хийх, гэрээ хэлэлцээр байгуулах, ёслолын арга хэмжээнд оролцохгүй байх;

2.2.9. Байгууллагын ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг эрчимжүүлж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам болон бусад эрх зүйн баримт бичгүүдийг мөрдөн, хэрэгжүүлж ажиллах, “Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт” дэд системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, ашиглалтыг сайжруулах, ёс зүйн мэдээллийг бүрэн оруулах, хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.2.10. Цахим засаглалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх /байгууллагын вебсайт, пэйж хуудастай болж, өдөр тутмын үйл ажиллагааг сурталчлах, журмын дагуу тогтмол, бүрэн хөтлөх, аймгийн Засаг даргын Тамгын газрын вебсайттаа холбох/;

2.2.11. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах /shilendans.gov.mn сайтын хөтлөлтийг тогтмол хийж, хугацаанд нь баяжуулж байх/;

2.2.12. Байгууллагынхаа орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтийг хамарсан мод тарих ажилд идэвхтэй оролцох /2025 онд 500 ширхэг мод тарих/;

2.2.13. Байгууллагын ойр орчмын агаар, орчны бохирдлыг бууруулах, хөрсний доройтлоос сэргийлэх, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, хэрэгжүүлэх;

2.2.14. Хугацаатай албан бичиг, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд барагдуулах, хариу өгөх, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, мөн түүнтэй холбогдолтой Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар авсан арга хэмжээ, иргэдийн өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай тайлан мэдээг улирал бүрийн 4, 7, 10 дугаар сарын 01-ний дотор, жилийн эцсийн мэдээг дараа оны 01 дүгээр сарын 01-ний дотор өссөн дүнгээр тооцож хавсралтын дагуу гаргаж тайлагнах;

2.2.15. Албан хэрэг хөтлөлтийн дотоод сүлжээний ERP програмыг нэвтрүүлж, ашиглаж хэвших ERP програмыг холбосон сумын бичиг хэргийн ажилтныг програмд тогтмол ажиллуулах, хэрэгжилтийг хангуулах. Жилийн турш үйл ажиллагаандаа Монгол улсын Засгийн газрын Е-Монголиа цахим порталыг бүрэн нэвтрүүлэх;

2.2.16. Төрийн захиргааны албан тушаалын болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сул орон тоог хууль журмын дагуу нөхөх, хуульд заасан хугацаанд сул орон тооны захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд шуурхай ирүүлж байх. Хууль бус томилгоо хийхгүй байх, томилгооны зөрчлийг арилгуулах;

2.2.17. Аймгийн Засаг даргын 2024 оны А/1111 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээний сул орон тоо, шинээр бий болсон ажлын байрны холбогдолтой мэдээллийг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт тухай бүр батлагдсан маягтын дагуу гаргаж, ажлын байрны сул орон тоо гарсан тохиолдолд бүртгүүлж, тухай бүр захиалга өгч ажиллах;

2.2.18. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу төрийн нэгдсэн цахим систем [www.gov.mn](http://www.gov.mn) болон шилэн ажиллагааны цахим систем [shilen.gov.mn](http://shilen.gov.mn) цахим хуудсанд мэдээ, мэдээллүүдээ тогтмол байршуулж баяжуулах;

2.2.19. Аймгийн удирдах ажилтны шуурхай хуралд 7 хоног болгоны Баасан гарагийн 08:00 цагт тогтмол оролцож, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, тухай бүр чанартай, үр дүнтэй ирүүлж байх;

2.2.20. “Авлигын эсрэг нэгдье” үйл ажиллагааны хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол хийж хэрэгжүүлэн үр дүнг тайлагнаж байх;

2.2.21. Аймгаас батлагдсан дэд хөтөлбөрүүдийг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах;

2.2.22. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, хууль, үндэсний болон аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах;

2.2.23. Өвөлжилтийн бэлэн байдлыг бүрэн хангуулах;

2.2.24. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдал, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 9 дүгээр хавсралтад заасан үйл ажиллагааны болон хүний нөөцийн ил тод байдал, Засгийн газрын “Сахилга хариуцлага, дэг журмыг

чангатгах тухай” 2018 оны 258 дугаар тогтоол, Засгийн газрын “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 388 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/519 дүгээр захирамж, Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дугаартай албан даалгаварын хэрэгжилтийг хангуулах;

2.2.25. Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ахмадын сан байгуулж хөрөнгө санхүү төвлөрүүлэн ахмадуудад үйлчилгээ үзүүлэх

2.2.26. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дараах тайлангуудыг заасан хугацаанд Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон аймгийн Засаг даргын 2024 оны А/519 дүгээр захирамжийн хавсралтын дагуу чанартай, бүрэн, үнэн зөв, стандартын дагуу гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ. Үүнд:

| №                     | Тайлангийн төрөл                                               | Тайлан, мэдээ хүргүүлэх байгууллага         | Тайлан хүргүүлэх хугацаа | Тайлан хүлээн авах байгууллага, нэгж                   | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, хугацаа         | Дээд шатны байгууллага д тайлагнах хугацаа                  |
|-----------------------|----------------------------------------------------------------|---------------------------------------------|--------------------------|--------------------------------------------------------|-------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|
| 1                     | 2                                                              | 3                                           | 4                        | 5                                                      |                                                             | 7                                                           |
| Бодлогын баримт бичиг | “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 11.15                    | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс                    | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 11.20                   | Засгийн газарт 11.25                                        |
|                       | Хөгжлийн зорилтот хөтөлбөр                                     | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 07.10                    | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 07.20                   | Эдийн засаг хөгжлийн яам 08.01                              |
|                       | Төрөөс баримтлах бодлого                                       | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 12.20                    | Аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэст                      | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 01.15                   | Төрийн захиргааны төв байгууллага д 02.01                   |
|                       | Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл              | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 12.15                    | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 12.20                   | Эдийн засаг хөгжлийн яам 01.01                              |
|                       | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр                        | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 12.10<br>06.10           | Аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс                       | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 12.20<br>06.25-ны Дотор | Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 01.01.<br>07.01-ны дотор |
|                       |                                                                | Аймгийн ЗДТГ-ын хэлтсүүд                    | 12.00<br>06.15           |                                                        |                                                             |                                                             |

|                                                           |                                             |                |                                                        |                                                              |                                                                     |
|-----------------------------------------------------------|---------------------------------------------|----------------|--------------------------------------------------------|--------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------|
| Үндэсний хөтөлбөр                                         | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 01.10          | Аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс                       | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 01.20-ны дотор           | Холбогдох яамд 02.10-нд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 04.01-нд |
| Улсын                                                     | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 06.15<br>12.15 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 06.20<br>12.20 -ны дотор | Холбогдох яам-д 01.01-ны дотор                                      |
| Төсөл, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа хөтөлбөр | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 12.20          | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс                    | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 01.10-ны дотор           | Төрийн захиргааны төв байгууллага д 01. 20-ны дотор                 |
| Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл              | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 12.20          | Аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс                       | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 01.15-ны дотор           | Эдийн засаг хөгжлийн яам 03.01-ны дотор                             |
| Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр             | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 10.25          | Аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс                       | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 11.15-ны дотор           | Аймгийн ИТХ-д 12.01-ний дотор танилцуулна                           |
| Аймгийн дэд хөтөлбөр                                      | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 11.01          | Аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс                       | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 11.15-ны дотор           | Аймгийн ИТХ-д 12.01-ний дотор танилцуулна                           |
| Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө                        | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 11.01          | Аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс                       | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс 11.15-ны дотор           | Аймгийн ИТХ-д 12.01-ний дотор танилцуулна                           |
| Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр               | Сумын Засаг даргын Тамгын газар             | 12.25          | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст                   | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс                          | Аймгийн Засаг даргын                                                |

|                                            |                                                                                                                                       |                                                      |                |                                               |                                                                              |                                                                                 |
|--------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------|----------------|-----------------------------------------------|------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------|
|                                            | хөгжлийн<br>жилийн<br>төлөвлөгөө                                                                                                      |                                                      |                |                                               |                                                                              | зөвлөлд<br>танилцуулна<br>01.15                                                 |
| Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт | Монгол Улсын<br>хууль, УИХ-ын<br>шийдвэр,<br>Ерөнхийлөгчийн<br>зарлиг, ҮАБЗ-<br>ийн зөвлөмж,<br>Засгийн газрын<br>тогтоол,<br>шийдвэр | Засаг даргын<br>дэргэдэх<br>агентлаг,<br>байгууллага | 06.10<br>12.10 | Аймгийн<br>ЗДТГ-ын<br>холбогдох<br>хэлтэс     | Хяналт-<br>шинжилгээ,<br>үнэлгээний<br>хэлтэс<br>12.20<br>06. 20-ны<br>дотор | Засгийн<br>газрын хэрэг<br>эрхлэх<br>газарт<br><br>02.15.<br>07.10-ний<br>дотор |
|                                            | Аймгийн<br>Иргэдийн<br>төлөөлөгчдийн<br>хурлын<br>тогтоол,<br>шийдвэр                                                                 | Засаг даргын<br>дэргэдэх<br>агентлаг,<br>байгууллага | 06.10<br>11.10 | Аймгийн<br>ЗДТГ-ын<br>холбогдох<br>хэлтэс     | Хяналт-<br>шинжилгээ,<br>үнэлгээний<br>хэлтэс<br>06.15<br>11.15-ны<br>дотор  | Аймгийн<br>ИТХ-д<br>06.25<br>11.20-ны<br>дотор                                  |
|                                            | Аймгийн Засаг<br>даргын<br>захирамж,<br>албан<br>даалгавар                                                                            | Засаг даргын<br>дэргэдэх<br>агентлаг,<br>байгууллага | 06.10<br>12.10 | Аймгийн<br>ЗДТГ-ын<br>холбогдох<br>хэлтэс     | Хяналт-<br>шинжилгээ,<br>үнэлгээний<br>хэлтэс<br>06.20<br>12.20-ны<br>дотор  | Аймгийн<br>Засаг<br>даргын<br>зөвлөлд<br><br>06.25<br>12.25-ны<br>дотор         |
| Байгууллагын үйл ажиллагаа                 | Засгийн газрын<br>гишүүний<br>аймгийн Засаг<br>даргатай<br>байгуулсан<br>гэрээний<br>үүргийн<br>биелэлт                               | Засаг даргын<br>дэргэдэх<br>агентлаг,<br>байгууллага | 06.15<br>12.10 | Аймгийн<br>ЗДТГ-ын<br>холбогдох<br>хэлтэст    | Гэрээнд<br>заасан<br>хугацаанд<br>холбогдох<br>яаманд<br>хүргүүлнэ.          | ЗГХЭГ-т<br><br>3 дугаар<br>сарын 1-ний<br>дотор                                 |
|                                            |                                                                                                                                       | Аймгийн<br>ЗДТГ-ын<br>хэлтсүүд                       | 06.20<br>12.15 | Хяналт-<br>шинжилгээ,<br>үнэлгээний<br>хэлтэс |                                                                              |                                                                                 |
|                                            | Аймгийн Засаг<br>даргын Тамгын<br>газрын<br>гүйцэтгэлийн<br>төлөвлөгөөний<br>биелэлт                                                  | Аймгийн<br>ЗДТГ-ын<br>хэлтэс, нэгж                   | 06.20<br>12.20 | Төрийн<br>захиргааны<br>удирдлагын<br>хэлтэст | Хяналт-<br>шинжилгээ,<br>үнэлгээний<br>хэлтэс<br>06.25<br>12.25              | Аймгийн<br>Засаг даргад<br>07.10<br>01.10<br><br>ЗГХЭГ-т<br>03.01               |
|                                            | Монгол улсын<br>Засгийн газрын<br>тэргүүлэх ач<br>холбогдолтой                                                                        | Засаг даргын<br>дэргэдэх<br>агентлаг,<br>байгууллага | 12.10          | Хөгжлийн<br>бодлого,<br>төлөвлөлт,<br>хөрөнгө | Хяналт-<br>шинжилгээ,                                                        |                                                                                 |

|                                                                                                     |                                             |                |                                                               |                                                              |                                                                                                    |
|-----------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------|----------------|---------------------------------------------------------------|--------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------|
| төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайлан /Ногоон байгууламж, Хог хаягдлын менежмент, Цахим шилжилт/ | Сумын Засаг даргын Тамгын газар             |                | оруулалтын хэлтэс<br><br>Төрийн захиргааны удирдлагын хэлтэст | үнэлгээний хэлтэс<br><br>12.15                               | ЗГХЭГ-т<br><br>12.25                                                                               |
| Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан                  | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 12.10          | Төрийн захиргааны удирдлагын хэлтэст                          | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс<br>12.15                 | Засаг даргатай байгуулсан гэрээний үнэлгээнд оруулна<br>01.10<br><br>ЗГХЭГ-т<br>03.01              |
| Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын тайлан                                             | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 12.20          | Төрийн захиргааны удирдлагын хэлтэст                          | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс<br>01.01                 | Засаг даргатай байгуулсан гэрээний үнэлгээнд оруулна<br>01.10<br><br>ЗГХЭГ-т<br>03.01<br>тайлагнах |
| Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт                                                  | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 06.17<br>12.15 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс                           | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс<br>12.20                 | Аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулна                                                           |
| Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт                                                     | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 06.15<br>12.15 | Аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс үнэлгээ хийнэ                | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.<br>07.01.<br>12.25-ны дотор | ХШҮХ үнэлгээнд оруулна<br>01.10-ны дотор                                                           |
| Тухайн жилийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан                                   | Сумын Засаг даргын Тамгын газар             | 01.01          | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс                           | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс                          | Засаг даргын зөвлөлд<br><br>01.20-ны дотор танилцуулна                                             |

|                    |                                                                 |                                             |                                                         |                                    |                                     |                                                                                           |
|--------------------|-----------------------------------------------------------------|---------------------------------------------|---------------------------------------------------------|------------------------------------|-------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|
| Бусад тайлан мэдээ | Хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн биелэлт | Сум, байгууллагууд                          | 12.25                                                   | ХШҮХ болон бусад холбогдох хэлтэст | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс | Засаг даргын зөвлөлд 01.20-ны дотор танилцуулна                                           |
|                    | Байгууллагын ёс зүйн зөвлөлийн тайлан                           | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 05.25<br>11.25                                          | Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс |                                     | ХШҮХ үнэлгээнд оруулна 01.10-ны дотор                                                     |
|                    | Өргөдөл, санал, гомдлын тайлан                                  | Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллага | 04.01.<br>07.01.<br>10.01.<br>Дараа оны 01.01-ний дотор | Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс |                                     | Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 04.10.<br>07.10.<br>10.10.<br>Дараа оны 01.10-ны дотор |

- Цахим Засаглал нэвтрүүлсэн ажлын талаарх тайлан
- Ногоон хөгжил-Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан
- Хогны менежмент /Амар тайван - аюулгүй нийгэм зорилтын хүрээнд/-ийн чиглэлээр хийсэн ажлын тайлан

### 2.3. Талуудын харилцан хүлээх үүрэг:

2.3.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудын хамаарах заалтуудыг баримталж ажиллана;

## ГУРАВ. ГЭРЭЭНИЙ УРАМШУУЛАЛ БА ХАРИУЦЛАГА

3.1. Байгууллагын удирдлага нь гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн тохиолдолд түүнийг урамшуулах асуудлыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

3.2. Байгууллагын удирдлага нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт болон энэхүү гэрээний заалтыг зөрчсөн нь тогтоогдвол хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэх үндэслэл болно. Харин гэмт хэрэг, авлига, ашиг сонирхлын шинжтэй болох нь тогтоогдвол холбогдох хуулийн байгууллагад харьяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

3.3. Энэхүү гэрээний биелэлтийн дүнгээр хангалтгүй үнэлгээ авсан нэгжийн удирдлагад Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон аймгийн Засаг даргын 2021 оны А/751 дүгээр захирамжаар баталсан журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## ДӨРӨВ. БУСАД ЗҮЙЛ

### 4.1 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

4.1.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэж, албажуулан гэрээнд хавсаргана. Энэхүү гэрээний хугацаа сунгагдахгүй.

### 4.2 Гэрээ байгуулах болон дүгнэх хугацаа:

4.2.1. Гэрээг 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний хүртэл 1 жилийн хугацаатайгаар байгуулж, 2 хувь үйлдэв.

4.2.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг жилд нэг удаа дүгнүүлэх бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн дотор хэрэгжилтийн үр дүнг тооцон, аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэст хүргүүлж дүгнүүлнэ.

4.2.3. Байгууллагын удирдлага нь гэрээний 2.2 дахь хэсэгт заасан үүргийн биелэлтийг жилд нэг удаа дүгнүүлэх бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн дотор биелэлтээ гаргаж, аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнаж дүгнүүлнэ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
(албан тушаал)

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

/ Е.ЗАНГАР /  
(гарын үсэг)

Огноо 2025.02.07

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Х.АНЖЕЛИКА/  
(албан тушаал)

(гарын үсэг)

Огноо 2025.02.07